



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 5/85

Улаанбаатар хот

Мөнгөн шагнал олгох тухай

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.8 дахь заалт, 9.6.10 дахь заалт Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ын 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Онц түвэгтэй даалгаврыг биелүүлж, Монгол Улсын 21 аймгийг нийслэл Улаанбаатар хоттой холбох "Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км хатуу хучилттай авто замын бүтээн байгуулалтын ажлыг хугацаанд нь хэрэгжүүлэхэд мэргэжлийн өндөр ур чадвар гаргаж, удирдан зохион байгуулсан Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Оюундэлгэр, мэргэжилтэн Б.Ууганбаяр, Сайдын хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтан Х.Болортуяа нарт нэг сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн шагналыг тус тус олгосугай.

2.Мөнгөн шагналд олгогдох зардлыг зохих зардлаас гаргахыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс (Ч.Ренчиндамба)-т зөвшөөрсүгэй.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА С.БАТБОЛД



080000560